

Г.В.Ф ГЕГЕЛИЙН “ЛОГИКИЙН ШИНЖЛЭХ УХААН”-Ы ҮҮДНЭЭС
СЭТГҮҮЛ ЗҮЙГ ТОДОРХОЙЛОХУЙ

Б.Болд-Эрдэнэ*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, сэтгүүл зүйн доктор (Ph.D)

Түлхүүр үгс: Гегель, сэтгүүл зүй, мэдээлэл, мэдээ, сэтгүүл зүйн мөн чанар, баримт, хэрэглэгч, ахуй ба үр нөлөө, сэтгүүл зүйн үүрэг, зарчим

Товч утга: Энэхүү өгүүлэл нь Гегелийн “Логикийн шинжлэх ухаан” гол категори болох ахуй (мэдээлэл), ахуй бус (үр нөлөө), бэлэн ахуй (мэдээ), ондооны хүрээнд сэтгүүл зүйн логикийн зарим үндсэн ойлголтыг тодорхойлох зорилгоор бичигдсэн болно.

Агуу их сэтгэгчдийн үзэл онол “мөнхийн ус уусан мэт аль ч цаг үе, ямар ч нийгэм, орчинд үнэ цэн утга тайлбараа үл гээн оршдог нь гайхалтай бөгөөд золтой хэрэг юм. Ийм нэгэн эрхэм, хүн төрөлхтний оюун ухааны гэрэлт хөшөө Гегелийн “Логикийн шинжлэх ухаан” гурван ботийг орчуулан, өчүүхэн миний нүд сэтгэлийг нээсэн эрхэм гүүш Ч.Даваадаш абугайн буян ч Монголын нийгмийн сэтгэлгээнд үргэлжид орших болтугай. Олныг эс нуршин, бөх зүрх гарган сэтгүүл зүйн логикийн зарим (чухал) ойлголтыг тодорхойлох нэгэн бичил өгүүллээ (санаагаа) эхэлсүү. Гэхдээ хамгийн гол категори болох

ахуй, ахуй бус, бэлэн ахуй ондооны хүрээнд хязгаарласан болно.

Сэтгүүл зүйн ахуй бол мэдээлэл мөн. Харин ахуй бус нь үр нөлөө юм. Мэдээллийн өөртөө буй ахуй нь баримт бөгөөд өөрөө өөрийгөө л илэрхийлж байдаг. Өөрөөр хэлбэл мэдээллийг ойлгох, төсөөлөх, дүрслэх нь мэдээлэлд ялгаагүй төдийгүй өөрөө өөртөө оршиж буй зүйл юм. Бидний үл таних, мартагдсан соёл иргэншлийн бичиг үсгээр тэмдэглэгдэн үлдсэн дурсгал “мэдээлэл” нь жинхэнэ ахуйн бодит жишээ мөн бөлгөө. Гэвч дурсгал нь бас ахуйн эсрэг чанар юу ч бус бас мөн. Учир нь бид дурсгалт бичээсийг уншиж, ойлгож, дүгнэж чадахгүй байгаагаас “эс оршиж буй” хэмээн тодорхойлж болно. Гегель “юу ч бусыг голдуу (аливаа) нэгэнд сөргүүлэн тавьдаг. Гэвч нэгэн бээр нь нөгөө нэгэн бээрээс ялгаатай хэдийнээ тодорхой оршин буй юм; тийнхүү (аливаа) нэгэнд сөргүүлэн тавьдаг юу ч бус нь ямар нэг нэгэн бээрийн юу ч бус, тодорхой юу ч бус мөн” гэж (Ч.Даваадаш о. , 2021) төсөөлөл дэх ахуй, юу ч бусын (ахуй бусын) эсрэг тэсрэг чанарыг тодорхойлжээ. Тэхлээр үл мэдэгдэх бичгийн дурсгал нь нэг талаас ахуй (бодитоор оршин

буй) нөгөө талаас юу ч бус тул Гегелийн “ахуй ба ахуй бус нь” нэгэн адил гэсэн дүгнэлтийг нотолж байна. Өөрөөр хэлбэл мэдээлэл нь эерэг буюу ойлгогдож, утга санааг нь мэдэх аваас ахуй, сөрөг буюу үл таних авахаас юу ч бус болно. Үүнийг ч “Төгсгөлтэй, тодорхой ахуй бол өөр ахуйтай бол холбогддог тийм ахуй юм. (Мөн зохиол, тал 159, 2021). Тэр бол өөр агуулгатай, бүх ертөнцтэй зайлшгүй холбогддог тийм ахуй юм гэж ялган тодотгожээ. Үнэхээр ч мэдээлэл нь тэмдэгтийн тайлал, мэдээлэгч ба хэрэглэгч хоорондох ойлголцол төвшин, цаг үе нөхцөл байдлын нөлөө гээд олон хүчин зүйл, холбогдлын дунд сая бодит болон үнэлэгдэнэ. Энэ утгаараа хүртэн, ойлгож, дүр төсөөлөл өдөөж буй мэдээ нь (бэлэн ахуй) ба юу ч бус хоёрын хоорондох ялгаа, нэгэн бээрийг ба ондоог агуулж байдаг. Цаашилбал ахуй ба ахуй бус нь нэгдэл гэхдээ шууд утгаараа бус өөр өөрийнхөөрөө бие даасан гэхдээ устган хадгалагдсан бүрэлдэл гэсэн дүгнэлт урган гарна. Эндээс мэдээлэл (ахуй) ба үр нөлөө (ахуй бус) хоорондын логик уялдаа бол мэдээлэл нь үр нөлөө рүү шилжиж үр нөлөө нь мэдээллийг агуулдаг гэсэн зүй тогтолтой гэсэн дүгнэлтэд хүрнэ. Гэхдээ мэдээлэл нь өөрийгөө устган хадгалах нь аль нэг тодорхойлолт уруу буцаж буй үйл явцаар үүсэл улирахуйд (шилжилт) оршино. Мөн “нэгэн бээр өөрийгөө устган хадгалдаг тэр нь юу ч бус болон хувирдаггүй... дамжмал нэгэн (Мөн зохиол, тал 187, 2021) гэжээ. Сэтгүүл зүйн онолын гол асуудал болох баримт ба үзэл бодлыг ялгах, мэдээллийн “цэвэр баримтын цогц байх” тухай үзэл номлолын зөрчил нь чухамдаа дээр

өгүүлсэн ахуй ба юу ч бусын (ахуй бусын) нэгдмэл гэхдээ тус тусдаа бие даасан, бодит байдал, цаг үеийн нөхцөлийн үүднээс үнэлэлт (дамжмал байдал) зэргийг ялгаж ойлгоогүй, хуурмаг бодомжид хэт шүтсэнээс үүдсэнд болно. Энэ шалтгаанаар хамгийн үр нөлөөтэй ухуулга, сурталчилгаа бол мэдээлэл, хамгийн үнэтэй чухал мэдээлэл бол ухуулга сурталчилгаа юм гэсэн томъёолол байж болно. Гэхдээ энд мэдээлэл бол мэдээлэл, ухуулга бол ухуулга гэсэн чанарыг гээгээгүй бөгөөд нэг тал гэдгийг шилжилт, бүрэлдэл дунд тодорхойлж буйг онцлон хэлмээр байна. Түүнчлэн Аристотелийн сайн шүүмж бол зөвлөгөө (магтаал) байдаг гэсэн үгийг ч ойлгож болно.

Мэдээ бол бэлэн ахуй юм. “Ахуй...бэлэн ахуйд шилждэг, бэлэн ахуй юм” (Мөн зохиол, тал 153, 2021). Гэхдээ бэлэн ахуй бол ахуй ба юу ч бусын энгийн нэгдэл “ахуй бустай ахуй учир энэ ахуй бус нь ахуйтай энгийн нэгдэлд авагддаг” (Мөн зохиол, тал 190, 2021) байна. Мэдээ нь тодорхой мэдээлэл бөгөөд бусад мэдээтэй эсрэгцдэг, хувьсамтгай (хүн бүр өөрийнхөөрөө), төгсгөлтэй (тохиолдлын), сөргөөр тодорхойлогдсон (явцуу, цогц бус) байдаг. Энэхүү чанар нь бүх мэдээнд төгсгөлгүй үргэлжилж байдаг учир мэдээнүүдийн үгүйсгэл, үгүйсгэлийн хууль болдог. Гегель ч “үгүйсгэл нь юуны өмнө төгсгөлтэй нэгэн бээрийн хувьд төгсгөл үгүй юм. Эдгээр тодорхойлолтын илрэн гарч ирдэг хийсвэр эсрэг тэсрэг чанар нь эсрэг тэсрэг нь үгүй болсон төгсгөлгүй чанарт болон өөрийн төлөө ахуй болон шийдвэрлэгддэг гэжээ. (Мөн зохиол, тал 189, 2021) Тэхлээр тухайн мэдээ, мэдээлэл нь (ахуй) ба үр нөлөө (ахуй бусын)

бүрэн нэгдэл бөгөөд аль алиныг нь тодотгодог бас өөрийнхөөрөө оршдог бэлэн ахуй мөн төдийгүй бусад мэдээний шинэчлэлт баяжуулалтаар үгүйсгэгдэж басхүү өөрийн агуулгаар хадгалагдан шинээр үнэлэгддэг чанар бүхий болно. Харин мэдээний тодорхой чанар (ямар нэгэн үйл явдал, үзэгдлийг заан өгүүлсэн утга) нь байрласан тодорхой чанар (тухайн цаг үеийн тохиолдлын) юм. Тиймээс мэдээллийн (ахуй) талаас өрөөсгөл тодорхой чанартай (хэсэг бусаг баримт) учир ерөнхий тоймыг хүргэж, (утга санааг дамжуулж) болох ч цогц бүрэн дүүрэн мэдээлэл биш юм. Гэхдээ мэдээж мэдээллийн урсгал, орчинд тохирч байдаг.

Гегель "...ахуй ба юу ч бус нь бэлэн ахуйд нэгдмэл байдаг, тэдгээр нь бие биеийнхээ хязгаараас гардаггүй. Бэлэн ахуй хэдий чинээ оршихуй мөн байна төдий чинээ тэр нь ахуй бус (мэдээлэл бус) тодорхой байдаг. Ахуй бол түгээмэл зүйл биш, тодорхой чанар бол онцгой зүйл биш маш энгийн дам бус нэгэн... илүү ерөнхий зүйл мөн (Мөн зохиол, тал 192, 2021). Энэхүү чанар нь "юу ч бусын тодорхойлолтод ч адилхан байрласан байх ёстой" (Мөн зохиол, тал 192, 2021) гэжээ. Үнэхээр мэдээний гол чанар нь энгийн, түгээмэл (сонирхолтой, цаг үеийн) байхад оршдог, асуудлын шалтгаан, учир зүйн холбогдлыг хомс багтаадаг, хэсэг бусаг баримт нь өргөн хүрээнд ядмаг, зөрчилтэй (үгүйсгэлтэй) байдаг оршино. Тэгвэл мэдээний бодит байдал (үнэн) юунд орших вэ гэдэг асуулт урган гарна. Үүнийг Гегель "Бодит байдал бол чанар, бэлэн ахуй юм. Тийнхүү тэр нь үгүйсгэлийн талыг агуулж байдаг бөгөөд гагцхүү үүнийхээ ачаар л тэр нь тодорхой зүйл

байдаг. Тодорхой чанар бол батлахуй мэт байрласан үгүйсгэл мөн (Мөн зохиол, тал 195, 2021) гэж тодорхойлжээ. Мөн... бодит байдал гэдэгт одоохондоо нуугдмал байгаа тэр сөргүү зүйл гэрэлтэж байдаг" (Мөн зохиол, тал 196, 2021) хэмээн тодотгожээ. Тиймээс мэдээний бодит байдал хэмээхүй нь харьцангуй бөгөөд хэдий чинээ эерэг, сөрөг хандлага байр суурийг агуулна төдий чинээ үнэнд ойртох болох нь ээ. Үнэхээр ч тэнцвэрт байдлыг хадгалах, толерант (хүлцэл, тэвчил) хандлагыг эрхэмлэх нь мэдээний төдийгүй сэтгүүл зүйн үндсэн зарчим байж сая бодит үнэнийг гэрэлтүүлэх магадлал өснө. Нөгөөтээгүүр мэдээний тодорхой чанар гэдэг нь бодит байдлын болон үгүйсгэлийн ялгаанд оршиж буй бөгөөд энэхүү ялгааг устган хадгалах нь тодорхой чанар болж, илт оршигч нэгэн бээр болдог байна. Тэхлээр мэдээний үнэ цэн нь үгүйсгэлийн анхны үгүйсгэлд тодорхойлогдох бөгөөд өөртэйгөө холбогдох энгийн холбогдлоо сэргээн тогтооход эрэмбэлэгдэнэ. Өөрөөр хэлбэл мэдээ нь хэдийгээр хийсвэр өнгөц боловч, үгүйсгэлийн үгүйсгэлд буюу баттай бус хэмээгч (ядмаг, хэсэг бусаг, цогц бус) чанарынхаа эсрэг нотолгоог (эх сурвалжийн чанар) агуулж байж сая үнэнд дөхнө гэсэн үг. Цаашилбал Гегель "...сэргээн тогтоох явдал юм өөрөө өөртэйгөө өөрийгөө дамжуулахуй юм... Тэр нь хэдийнээ бүрэлдээд байж байдаг, гэвч түүнд тэр нь зөвхөн тун хийсвэр дамжихуй" (Мөн зохиол, тал 199, 2021) гэжээ. Мэдээ тодорхой утга мөн боловч (дам, дам бус чанар) нөлөө, тайлал, шалтаан гээд (дамжихуй тал) олон хүчин зүйлсийн хүрээнд өөр, ондоогоор (бүр эсрэгээр) үнэлэгддэг. Тодруулбал

“нэгэн бээр... эхэндээ тэр өөртэйгөө холбогдох өөрийн холбогдолд өөрийгөө хадгалсан маягаар байрладаг, харин түүний үгүйсгэгч чанар нь нэгэн зүйл мөн тийм чанарлаг зүйл болон ерөөсөө зөвхөн ондоон болон байрладаг.” (Мөн зохиол, тал 199, 2021) гэжээ. Аливаа мэдээ нь анхдагч мэдээллээ хадгалан тээгч, илэрхийлэгч боловч нөлөөлөл (ондоон) нь “өөрийг онилдог” яг ийм тийм байна гэж тодорхойлоход төвөгтэй (ер нь боломжгүй) байдаг нь дамжмал чанартай, ахуй ба юу ч бустай байдаггүй (уг чанараараа мэдээлэл, үр нөлөөтэй холбоогүй) гэсэн дүгнэлтийг тодотгож байна. Олон нийтийн харилцааны үр нөлөө ч “мэдээ”-г уншиж байхад юм уу уншсаны дараа бус (харилцаа болон түүний дараах үе) харин уншихаас өмнө тогтсон үзэл байр сууриар (харилцааны өмнөх үе) тодорхойлдог билээ. Тиймээс ч олон нийтийн харилцааны (сэтгүүл зүй, пи ар, реклам сурталчилгаа зэрэг) гол илт нөлөөг баталгаажуулагч байр суурь, хандлагыг тодотгогч хэмээдэг. Энэ бүхэн ч Гегелийн “нэгэн бээр нь ондооны төлөө өөрийн ахуйд эсрэгцсэн өөртэй буй мөн” (Мөн зохиол, тал 200, 2021) гэсэн тодорхойлолтын яв цав нийцлийг хүлээн зөвшөөрөхөд хүргэж байна.



Мэдээ нь ч нөлөөллийг агуулж байдгаараа түүний төлөө ахуй бөгөөд үүгээрээ нөлөөлөл бас түүнийг зорилгоо болгосон үгүйсгэлд өртсөн, устган хадгалагч ахуй юм. Тиймээс нөлөөллийн төлөө хийгээд буй утга хэлбэр нь мэдээний хоёр тал, мөн утга хэлбэр нь (өөртөө буй ахуй) нөлөөллийг агуулж байдгаараа мэдээнээс ангид, бие даасан чанарыг тээх ба үүгээр тунгаан үзвэл мэдээ нь нөлөөллийн төлөөх хэрэгсэл төдий зүйл болно. Гэхдээ энэ нь мэдээг үгүйсгэж буй биш бөгөөд “хэрэгсэл зорилгоосоо илүү чухал” гэсэн дүгнэлтийг Гегель эрхэм онцлон баталсан бөлгөө



Үнэхээр мэдээ бол нөлөөллийн төлөө оршдог ба баримт, утга агуулгаараа цогц, бүрэн дүүрэн бус, хэсэг бусад үг санааны эсрэгцэл дунд бүтээгдсэн бүтээл билээ. Мөн мэдээ ба түүний нөлөөлөл нь бие биедээ хүртээлгүй, (яг таг холбоо, нөлөөлөхүйн зарчим үгүй) нөлөөлөл нь бие даасан, илт буй оршихуй юм. Цаашилбал “нэгэн бээр болон бас ондоон... нэгэн зүйл юм тэдгээрийн хооронд бас ямар ч ялгаа байхгүй... энэ адилсаг чанар нь зөвхөн

гадаад тунгаан тусгахуйд... өөр хооронд нь харьцуулсан харьцуулалтад байдаг” (Мөн зохиол, тал 204, 2021) гэжээ. Тэхлээр тодорхой нөлөө үзүүлсэн мэдээний агуулга илэрхийлэлд нөлөөллийн учир шалтгаан гэж үгүй бөгөөд бүх асуултын хариулт гагцхүү нөлөөлөлд оршин буй болох нь ээ.

Гэхдээ нөлөөллийг зөвхөн нөлөөлөл гэдгээр нь тунгааж үл болох бөгөөд тухайн мэдээнийх, түүний ондоон гэж үзэх хэрэгтэй. Хэдийгээр мэдээний нөлөөлөл уг мэдээ-

тэйгээ холбогддог ч бас бие даасан ойлголт мөн бөгөөд өөрөө өөрийнхөө ондоонд эсрэгцэх нь лавтай юм. Гэвч энэ тохиолдолд ч тухайн мэдээний нөлөөлөл хэвээр хадгалагдана. Өөрөөр хэлбэл нөлөөлөл нь өөр ондоон үр дагаврыг дагуулж болох ч мэдээтэй холбогдсон анхдагч, эхлэл

байдлаар олдохгүй гэсэн үг. Зөвхөн энэ дүгнэлтэд гэхэд л сэтгүүл зүйн судалгааны шинэ хандлага оршиж буй ба тодруулбал үр нөлөөг судлахдаа мэдээний “ондоон” болох бас өөр холбогдох үр дагавраас ангид байр сууринаас авч үзвэл илүү бодитой болох нь илэрхий байна. Мэдээ нь ч нөлөөллийг агуулж байдгаараа түүний төлөө ахуй бөгөөд үүгээрээ нөлөөлөл бас түүнийг зорилгоо болгосон үгүйсгэлд өртсөн, устган хадгалагч ахуй юм. Тиймээс нөлөөллийн төлөө хийгээд буй утга хэлбэр нь мэдээний хоёр тал, мөн утга хэлбэр нь (өөртөө буй ахуй) нөлөөллийг агуулж байдгаараа мэдээнээс ангид, бие даасан чанарыг тээх ба үүгээр тунгаан үзвэл мэдээ нь нөлөөллийн төлөө хэрэгсэл төдий зүйл болно. Гэхдээ энэ нь мэдээг үгүйсгэж буй биш бөгөөд “хэрэгсэл зорилгоосоо илүү чухал” гэсэн дүгнэлтийг Гегель эрхэм онцлон баталсан бөлгөө. Нөгөөтээгүүр Гегель “Тодорхойлолт бол өөртөө буй ахуй болох батлагч тодорхой чанар бөгөөд өөртөө буй ахуйд нэгэн бээр нь өөрийн бэлэн ахуйдаа өөрийг нь тодорхойлж буй ондоотой (нөлөөтэй) өөрийн сүлжилдэн холбогдолдоо эсрэгцэн... ижил чанараа хадгалан, ондооны-төлөө -өөрийн ахуй энэ ижил тэгшээ илрүүлэн авч адилаар үлддэг байна.” (Мөн зохиол, тал 208, 2021) гэжээ.

Мэдээний тодорхой чанар бол баримт мөн бөгөөд түүгээрээ утга, зохиол яруу найргаас ялгагддаг. Тиймээс баримтаас үүдэн ондоонд буй нөлөөтэй холбогдох чанараараа мэдээ нь янз бүрийн төрөл зүйл, хэлбэр байдлаар өргөжин дэлгэрч, улам бүрэн дүүрэн болдог. Тэхлээр баримт бол сэтгүүл зүйн тодорхойлолт мөн бөгөөд тодорхой чанар нь юм. Мэдээ нь ярилцлага,

өгүүлэл, тойм гээд төрөл зүйлээр, инфотаймент, эдутаймент зэрэг хэлбэршлээр сонин, радио, телевиз гэх мэтчилэн хэрэгслээр “задардаг” ч тодорхой чанараараа мэдээ хэмээх бэлэн ахуйд нэгтгэхдэх учиртай. Цаашилбал энэ цогц, бүрэн дүүрэн байдал нь нөлөөллийн төлөөх чанартай холбоотой бөгөөд мэдээний гол шинж болдог. Гегель “Нэгэн бээр өөрөө өөртөө юутай байдаг тэр нь чухамхүү тийм янзаар хуваагддаг бөгөөд энэ талаасаа бол энэ нэгэн бээрийн гадаад бэлэн ахуй байдаг ба... гэвч түүний өөртөө-буй-ахуйд хамаардаггүй байна. Тийнхүү тодорхой чанар бол шинж мөн” (Мөн зохиол, тал 209, 2021) гэжээ. Тиймээс баримт бол сэтгүүл зүйн тодорхой чанар мөн боловч бас түүнд хамааралгүй ялгаатай. “Тодорхойлолтын талаас нь нэгэн бээр нь өөрийн шинжид хүртээлгүй байдаг... Гэвч тодорхойлолт өөрөө шинжид шилждэг ба шинж ч мөн (өөрөө аяндаа) тодорхойлолтод шилждэг.” (Мөн зохиол, тал 212, 2021) гэдэг утгаараа баримт нь мэдээ болсноор, бас мэдээ нь баримт мэт үнэлэгдсэнээр үнэ цэнтэй болно. Энэхүү холбогдол нь мэдээж тодорхой заагийг нотолж, буй бөгөөд чухамхүү түүний ачаар л бид мэдээ ба баримтыг ялган таньж аль алиных нь мөн чанар, буйг тодорхойлдог. Тиймээс мэдээ гэж юу вэ? Баримтаасаа юугаараа ялгаатай, ямар байх ёстой зэргийг тодорхойлох боломжийг “баримт” нээж баримтын мөн чанар, “өргөжин тэлэлт”-ийг “мэдээ”-гээр тодотгодог. Үүнийг ч “Зааг бол дамжихуй мөн түүгээр нэгэн бээр ба ондоон нь дамжин буй ба буй бус байдаг” (Мөн зохиол, тал 213, 2021) хэмээн дүгнэжээ.

Мэдээ тодорхой хязгаарлагдмал, зааг бүхий өөрөө өөртөө буй бүрэлдэл учраас төгсгөлт чанартай, бэлэн ахуй юм. Мэдээ нь мэдээ мөн ч энэ түр зуурын хувьсан өөрчлөгддөг, буй болсонтойгоо ижил үгүй болох чанартай. Өөрөөр хэлбэл хуучны тухайлбал “Шинэ толь хэмээх бичиг” сонин нь тухайн цаг үедээ мэдээ байсан, өдгөө ч тийнхүү үнэлэгдэж буй ч мэдээ гэхээсээ түүхэн баримт, эх сурвалж болж, эдүгээ “тодорхой чанар”-аа гэсэн хэмээсэн үг.

Гэхдээ “төгсгөлт чанар нь бодворын (оюун бодлын нэг мугуйд) категори мөн байдаг. Ерөөсөө үгүйсгэл, шинж, зааг нь өөрийн ондоотой-бэлэн ахуйтай тасарч байдаг. Тэр ч байтугай өөрөө байгаагаараа хийсвэр юу ч бус нь хийсвэр байхаа больдог; гэвч төгсгөлт нь өөрт байдаг үгүйсгэл мөн бөгөөд тийм учраас өөрийн баталгаатайд эрс эсрэгцэж байдаг (Мөн зохиол, тал 220, 2021) ажгуу. Тэхлээр 1913 оны сониныг өнөөгийн сэтгүүл зүйтэй холбон үзэх боломжтой орон зай, хүрээ, учир, холбогдол бий бөгөөд тэр нь гагцхүү уг сонины агуулгад, хэлбэр дизайнд бус (энэ төгсгөлтэй) харин үр нөлөө, үнэ цэнд оршиж байна. Учир нь энэхүү монголчуудын гаргасан анхны хэвлэл нь өнөөдрийн сэтгүүл зүйд холбоотой хэвээр нөлөөллөө алдаагүй (ондоотой холбоотой) хэвээр төдийгүй”... түр зуур нь юу ч бус нь сүүлчийн мөч биш харин өөрөө болоод өнгөрдөг гэдгийг (илрүүлэн) харуулдаг” (Мөн зохиол, тал 220, 2021) үйл хэргийн жишээ билээ.

Түүнчлэн төгсгөлтэй тухай ойлголт нь хязгаар болон байвал захихуй гэсэн өөрийн-доторх-ахуй чанарыг агуулдаг. Үнэхээр зааг нь хязгаар байхын, өөр нэгэн буйтай

холбогдохын үрийг, байвал зохихуй нь үгүйсгэлд эсрэгцэн, өөртөө буй тодорхойлолтыг зааж төгсгөлт зүйлийн талууд болдог. Ийнхүү байвал зохихуй нь “төгсгөлтэй” салбарт өөрийн байртай, өөрийн хүчтэй байдаг. Тэнд тэр нь хязгаарлагдмалын эсрэг өөртөө-буй-ахуйгаас хатуу зуурч түүнийгээ... мөн чанарын болон дүрэм журмын хуваарь баталж байдаг. Үүрэг бол тусгаар хүсэл зоригийн эсрэг, амин хувийн дур хүслийн болон дур зоргын ашиг сонирхлын эсрэг чиглэсэн байвал зохихуй. Хүсэл зориг өөрийн хөдөлгөөнтэй чанараараа юу үнэнтэйгээс тасардаг, түүнд ямар нэг байвал, зохихуйн тухай бодох, түүний тухай сануулцаадаг билээ” (Мөн зохиол, тал 226, 2021) хэмээн тодорхойлжээ.

Сэтгүүл зүйн ёс зүй ч байвал зохихуй мөн бөгөөд гэхдээ энэ нь нийгмийн эрх ашиг хэмээх хязгаараас гарах гаралт, эцсийн хязгаар хэмээн ойлговол ямагт тогтвортой, мөнхийн хэмээн дүгнэж болохгүй. “Кантын болон Фиктийн философи нь байх ёстойг оюун ухааны зөрчлийг шийдвэрлэх дээд цэг хэмээн өргөмжилдөг гэвч энэ бол ердөө төгсгөлтэй хүрээнээ, ингэхлээр зөрчлөөс гарахыг үл хүссэн үзэл юм” (Мөн зохиол, тал 227, 2021) гэсэн нь ч ёс суртахууны зарчмыг хэт өндөрт тавин, хамгийн дээд эрхэмлэл, аливаа сорилт бэрхшээлийг шийдвэрлэгч хүч хэмээн үзэх учир дутагдалтай болно. Үүнийг ч өнөөгийн Монголын сэтгүүл зүй тэр дундаа нийгмийн сүлжээнд эрхшээгдсэн худал, төөрөгдүүлэлтийг “мэдээ, бат нот” харуулж байна. Гэхдээ энэ мэдээ ч “өөртөө төгсгөлтэй” бас төгсгөлгүй бөлгөө.

Төгсгөлт нь байвал зохихуй болоод хязгаарын өөр хоорондоо

сүлжилдсэн хоёр талын нэгдэл бөгөөд хязгаар нь зохихуйн үгүйсгэл, зохихуй нь хязгаарын үгүйсгэл болон оршиж зөрчилдөн, өөрийгөө устган хадгалж болоод өнгөрдөг. Тийнхүү төгсгөлт нь зүйл нь өөр нэг төгсгөлт зүйлийн болоод өнгөрсөн зүйл бол энэхүү үйл явц нь өөрийн хязгаарыг даван тэр нь байвал зохихуй байж өөрөө өөртэйгөө нийлдэг ажээ. Цаашилбал "...үгүйсгэлийн үгүйсгэл бол батлагч ахуй мөн тийнхүү өөрийн тодорхой чанараараа анхны үгүйсгэлтэй байдаг байвал зохих төгсгөлтэйн ондоон нь мөн, энэ ондоон бол төгсгөлгүй мөн болох" (Мөн зохиол, тал 228, 2021) хэмээн нэгтгэн дүгнэж болно. Бэлэн ахуй болсон мэдээ нь төгсгөлтэй буюу өөр нэгэн эхлэл болж, тэр нь бас өөр нэгийг "төрүүлснээр" мэдээлэл (ахуй) хэмээх төгсгөлгүй бүтээнэ. Төгсгөлгүй нь үгүйсгэлийн үгүйсгэл, батлахуй ахуй мөн бөгөөд ахуй нь хязгаарлагдмал чанараасаа гаран дахиад өөрийгөө сэргээн тогтоодог" (Мөн зохиол, тал 229, 2021). Үнэхээр мэдээ бол "сэтгүүл зүйн тоосго", эд эс бөгөөд түүний тасралтгүй үргэлжлэл, үйл явцаар мэдээлэл хэмээх "ертөнц" бий болж оршдог. Тиймээс мэдээ нь бэлэн ахуй талаасаа төгсгөлтэй, төгсгөлгүйд алга болдог (мартагдсан ач холбогдлоо гээдэг) боловч буй байдлаараа (баримт, утгыг тээгч, хадгалагч) төгсгөлгүй (мэдээлэл) хэвээр байдаг.

«

Үнэхээр мэдээ бол "сэтгүүл зүйн тоосго", эд эс бөгөөд түүний тасралтгүй үргэлжлэл, үйл явцаар мэдээлэл хэмээх "ертөнц" бий болж оршдог. Тиймээс мэдээ нь бэлэн ахуй талаасаа төгсгөлтэй, төгсгөлгүйд алга болдог (мартагдсан ач холбогдлоо гээдэг) боловч буй байдлаараа (баримт, утгыг тээгч, хадгалагч) төгсгөлгүй (мэдээлэл) хэвээр байдаг

»

Мэдээлэл нь буй байдлаараа мэдээний үгүйсгэл, ямар нэг өөр мэдээний нэгтгэл байдаг учир нэг талаар мэдээтэй эсрэгцдэг нөгөө талаас мэдээлэл нь устган хадгалалтаар тодорхой чанарыг олж авсан "мэдээ"-нд буцдаг болно. Тиймээс мэдээ (бэлэн ахуй), мэдээлэл (ахуй) хэмээх төгсгөлтэй ба төгсгөлгүй хоёр ертөнц хоорондоо эерэг болон сөрөг холбогдолд харилцан бие биеэ "агуулж" байдаг тул бид мэдээллийг мэдээний заагт хязгаар тогтоогч (мэдээ бол юу гэсэн асуултад бусад тодруулгын хамт хариулдаг) басхүү тодорхой агуулгад байж байдаг (төгсгөлтэйн төгсгөлгүй) "мэдээ" юм. Тиймээс мэдээлэл ба мэдээ гэсэн ойлголт нь байвал зохихуйн (төгсгөлгүйтэй холбогдох холбогдолд төгсгөлтэй) төвшинд салшгүй боловч бие биеийнхээ ондоонууд (ялгаатай бие даасан) бас тус бүрдээ ондоотой түүнтэйгээ нэгдсэн холбогдолд оршдог. Үүнийг Гегель "төгсгөлгүйд дэвших дэвшил болж илэрдэг... Энэ дэвшил бол зөрчил мөн бөгөөд тэр нь шийдвэрлэгдээгүй харин ямагт зөвхөн бэлхнээ байж байдаг маягаар илэрхийлэгдэнэ." (Мөн зохиол, тал 235, 2021) гэжээ. Тиймээс мэдээлэл ч гэсэн төгсгөлтэйг, мэдээ ч гэсэн төгсгөлгүйг даван гардаг. Өөрөөр хэлбэл сэтгүүл зүйн хөгжлийг мэдээллийн төгсгөлгүй өөрчлөлт, шинэчлэлт хэмээн үзэхүй дор мэдээгээр хязгаарлагдсан төгсгөлтэй

нэгдэл цаашилбал, бүр хөдөлгөгч хүч болж байдаг гэсэн үг.

Мэдээ ба мэдээлэл нь өөр хоорондоо сүлжилдэн бие биеэ “төрүүлдэг” боловч хараахан нэг нэгдэлд байдаггүй зугталт, түлхэлцэл, шинэ үйлдэлд холбоогүй мэт холбогдолд оршдог. Энэ холбогдлыг “төгсгөлгүй” дэвшилд цаашдаа тэдгээрийн холбогдол... нэгдүгээр төгсгөлтэй зүйл; хоёрдугаарт төгсгөлтэйн даван гарахуй явагддаг... төгсгөлгүй мөн; гуравдугаарт... шинэ зааг үүсдэг дахиад ямар нэгэн төгсгөлтэй зүйл үүсдэг” (Мөн зохиол, тал 242, 2021) гэж тайлбарлажээ. Тэхлээр мэдээ бол бодит зүйл бус харин төгсгөлгүй зүйл юм. Тэр утгаараа мэдээлэл юм. Ингэж мэдээний бодит чанар цаашилбал мөн чанар, ойлголт санааг тодорхойлох ёстой болох нь ээ. Тухайлбал “бодит байдал нь төгсгөлт бэлэн ахуй мөн байдаг тэр бодит чанарт шалтгаан өөрөө эсрэгцдэг байна. Тийнхүү үгүйсгэл нь санаан чанар хэмээн тодорхойлогддог... бэлэн ахуйг бодит зүйл хэмээн үздэг (Мөн зохиол, тал 246, 2021) зэргээр тодотгожээ. Үнэхээр мэдээг бодит зүйл хэмээн үзэх бүрэн боломжтой бөгөөд утга агуулга, хэлбэр, тэмдэгт зэргээрээ төдийгүй бэлэн ахуй болон авагдсан төгсгөлгүй чанарыг тээгч гэдгээрээ (мэдээллийг нэгтгэн бас нэгж) өндөр дээд утга бүхий бодит чанартай билээ. Тиймээс социализмын үеийн “Үнэн” сонин мэдээ нийтлэл нь үнэ цэнтэй бодит зүйл мөн бөгөөд өөрийн утга агуулгаасаа ангид шинийг өдгөө хүртэл тээж, өөр утга агуулгаар дахин дахин үргэлжилж буй нь гарцаагүй ба энэхүү зүй тогтол өнөөгийн “Өдрийн сонин”-д ч мөн адил давтагдах болно. Энд бид “Шинэ толь хэмээх бичиг”

(1913) “Үнэн” “Өдрийн сонин” нэг талаас бие даасан, өөр хоорондоо ондоо хэвлэл мөн боловч, мэдээллийн орон зайн бодит хүч, зүйл хэмээх утгаараа нэгэн бээр төдийгүй төгсгөлгүй үргэлжлэлийн бэлэн ахуй хэмээх дүгнэлт гарч байна. Энэ бол Монголын сэтгүүл зүйн хөгжлийг бүрэн зургаар харах логик юм мөн.

Цаашилбал “Төгсгөлт ба төгсгөлгүйг эсрэг тэсрэг чанар ба... нэгдэл гэсэн хоёр тодорхойлолттой байдаг боловч энэ хоёр бодлыг нэгтгэн дүгнэдэггүй” (Мөн зохиол, тал 247, 2021). Тиймээс мэдээ ба мэдээлэл хооронд нэгдэл болоод салалтын холбогдол болох шалтгаан ба үйлдэл салшгүй гэнэ. Шалтгаан нь үйлдэл, үйлдэл нь шалтгаан болдог учир холбогдлоор “шинэ шалтгаан өөрөө зөвхөн үйлдэл мөн” энэ бол шалтгаан ба үйлдлийн нэгдэл болой. Энэ шинэ шалтгаан нь ямар нэгэн ондооныг өөрийн шалтгаан болгодог. Энэ хоёр тодорхойлолтын цааш цаашдын эцэс төгсгөлгүйд хүртэлх салалт юм” гэсэн дэвшлийн зүй тогтлыг хангадаг ажээ. Сэтгүүл зүйн хөгжлийн хувьд ч төгсгөлт бүхэн (тодорхой нэг сонин, телевиз, радио эсвэл төрөл зүйл, сэдэв асуудал) өөрийн улиран одохуйн хугацаанд үүсэж, өсөж буурах жамтай ба үүний шалтгаан нь бодитой (нийгэм улс төрийн өөрчлөлт, хэрэглээ, амьдралын хэв маягийн хувьсал зэрэг) бөгөөд өөр үйлдэл, үр дагаврын эхлэл болж өнөөг хүрчээ. Тийнхүү шинэ өөр өвөрмөц мэдээний оршихуйн хэв маяг түрэн гарч, төгсгөлт, тодорхой “бэлэн ахуй” болон заагийг даван (найруулга-хөрөг-“Би” төвт пост) үгүйсгэлийн үгүйсгэлээс батлахуй гарч, үр дүн нь (сэтгүүл зүй болон хүн хоорондын харилцаа) тэдгээрийн (төрөл зүйлийн зэрэг) үнэн ба уг эхний

төлөв байдал болж таардаг. Өөрөөр хэлбэл аливаа өөрчлөлт, хөдөлгөөн, дэвшил нь нэгтгэгдэн шийдвэрлэгддэг чанарт оршдог гэсэн зүй тогтол сэтгүүл зүйд ч адил байна гэсэн үг. Нөгөө талаар ялгаварт чанар нь (төрөл зүйлийн ялгаа) нэгэн зэрэг тусгаар, бие даасан байдлыг олгодоггүй (мэдээ ба мэдээлэл хоорондын) харин тэдгээрийг нэгтгэдэг болой.

Эцэст нь эргэн тодотгоход сэтгүүл зүйн талаас мэдээллийн (ахуй) өөртөө буй тал бол баримт, өөрийн төлөө нь үнэн бөгөөд харин үр нөлөөний (ахуй бус) өөртөө буйг итгэн үнэмшүүлэл, өөрийн төлөөх талыг ятгалга гэж үзэж байна. Эндээс баримт бол ахуй, харин ухамсар нь үнэн болж таарч буй бөгөөд мэдээлэл нь (ахуй) үр нөлөөг (ахуй бусыг) агуулж бас түүнээ эсрэгцдэг болой. Тиймээс мэдээллийн талаарх аливаа үзэл баримтлал нь дан ганц нэг талыг баримжаалж дүгнэлт тайлбар хийх нь өрөөсгөл бөгөөд үүнд жишээлбэл, сэтгүүл зүйг (мэдээллийг) соён гэгээрүүлэх (үр нөлөө) үүрэгтэй хэмээн шууд нотлох нь зөрчилтэй ба харилцан шүтэлцээтэй, диалектик логигоор магадлах илүү үнэнд нийцэх нь ээ. Тиймээс ч асуултын хариулт төвөгтэй, яг таг бус төдийгүй эсрэг тэсрэгийн нэгдэлд үнэлэлт дүгнэлт гаргах ёстой болохыг Гегель эрхэм тодотгож буй хэрэг. Үнэхээр ч мэдээлэл ба үр нөлөө нь өөр хоорондоо ялгаатай, бие биедээ хүртээлгүй үүгээр бэлэн ахуй болох мэдээг бүтээдэг ажээ. Тэхлээр зөв, голчтой үнэлгээ нь ахуй ба ахуй бусын адилсал ба ялгааны эерэг талуудын хувиар устган хадгалсны үр (үйл явцаар) буюу мэдээллийг ч, үр нөлөөг ч нэгтгэн харгалзуулсан тохиолдолд сая үнэлэлт тайлбар үнэнд дөхнө. Түүнчлэн их сэтгэгчийн

“бодит үнэнд тулгуурлаагүй, хүний хүсэл зоригийн эрх чөлөө, сонголтын эрх чөлөө гэж байж болохгүй. Энэ эрх чөлөө бол заавал бодит байдлын суурьтай байх ёстой” гэсэн санааг нэмбэл сэтгүүл зүйн (харилцаа гэдэг утгаараа) мөн чанар нь амьдралын бадралд, гүнзгий ухагдахуун нь “баримт-мэдээ-мэдээлэл-үр нөлөө-баримт”-ын устган хадгалан төрүүлэгч тойрогт оршино.

Эшлэл

1. Ч.Даваадаш, орч. (2021). Гегель.Г. “Логикийн шинжлэх ухаан” боть 1. тал 153. Улаанбаатар.
2. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 187. Улаанбаатар .
3. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 192. Улаанбаатар .
4. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 220. Улаанбаатар .
5. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 228 . Улаанбаатар.
6. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 235. Улаанбаатар.
7. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 155. Улаанбаатар.
8. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 159. Улаанбаатар.
9. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 189. Улаанбаатар.
10. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 190. Улаанбаатар.
11. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 192. Улаанбаатар.
12. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 195. Улаанбаатар.
13. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 196. Улаанбаатар.
14. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 199. Улаанбаатар.
15. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 199. Улаанбаатар.
16. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 200. Улаанбаатар.
17. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 204. Улаанбаатар.

18. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 208. Улаанбаатар.
19. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 209. Улаанбаатар.
20. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 212. Улаанбаатар.
21. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 213. Улаанбаатар.
22. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 220. Улаанбаатар.
23. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 226. Улаанбаатар.
24. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 227. Улаанбаатар.
25. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 229. Улаанбаатар.
26. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 242. Улаанбаатар.
27. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 246. Улаанбаатар.

28. Ч.Даваадаш, орч. (2021). Мөн зохиол, тал 247. Улаанбаатар.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ч.Даваадаш, орч. (2021). Гегель.Г. "Логикийн шинжлэх ухаан" боть 1. Улаанбаатар.

Summary

This article defines some basic concepts of journalism within the main categories of Hegel's "Science of Logic": content (information), non-content (effect), content (news), and the subject. The roles, principles, nature, news, information and their effects of journalism were discussed.

Key words: Hegel, journalism, information, news, nature of journalism, facts, users, existence and effects, role and principles of journalism